

Цаг уур, орчны шинжилгээний газрын
2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн
01/11 дугаар албан бичгийн хавсралт

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	0.9	9.2
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0.7	6.8
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	4.9
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	4.9
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0.3	3.4
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0.4	4.0
Хэсгийн оноо				**4**	3.3	33.2
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0.9	9.2
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1.0	9.6
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.4	3.8
Хэсгийн оноо				**3**	2.3	22.6
7		Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	0.9	9.2

8	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*	1	1.0	9.7
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]	1	0.8	7.7
Хэсгийн оноо			**3**	2.7	26.6
Үнэлгээний нийт оноо, хувь			**10**	**8.2**	**82.4**

----oOo----

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

НЭГ. Товч танилцуулга

Цаг уур, орчны шинжилгээний газрын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь Газрын даргын 2024 оны 01 сарын 12-ны өдрийн А/08 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын төв орон нутгийн харьяа 25 байгууллагаас ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг нэгтгэв.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

1. УИХ-ын 04 сарын 18-нд батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж сургалт зохион байгуулахаар шийдвэрлэж ажилчдын дотоод сүлжээгээр ЗГ-ын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийг уриалсан мэдээллийг өдөр бүр нэг нэгээр сануулан, тайлбарлан хүргэж байна.

2. Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төлөвлөгөөт сургалтуудын тогтмол хийлээ. Үүнд:

- Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн АУ-ы доктор, дэд профессор М.Цэрэнбат "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр
- Монгол Улсын Ёс зүйн хорооны Ёс зүйн дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болорзул "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" сэдвээр
- Монгол Улсын Ёс зүйн хорооны Ёс зүйн хорооны Гомдол, мэдээлэл хариуцсан референт Д.Мөнхбат "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж" сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.
- Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Г.Ариунзаяа "Авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл, шалтгаан, нөхцөл" сэдвээр
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэцийн тэргүүлэх зэргийн эмч, Ёс зүйн салбар хороон дарга З.Цэндсүрэн "Сэтгэцийн эрүүл мэнд ба Ёс зүй, Стресс менежмент" сэдвээр тус тус төвийн болон салбар орон нутгийн албан хаагчдад цахимаар сургалт хийсэн.

3. Цаг уур орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хорооноос албан хаагчдад болон салбарын албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2 удаагийн цахим сургалтыг Ёс зүйн дэд хорооны дарга Н.Энхмаа, нарийн бичгийн дарга М.Батжаргал нар хийлээ.

Харьяа байгууллага

Өмнөговь аймгийн УЦУОШТ-ийн Ёс зүйн дэд хорооноос 2025 оныг "Байгууллагын соёл бол хувь хүний соёл мөн", сэдвээр Дундговь аймгийн УЦУОШТ "Эерэг харилцаа-Урмын үг", "Эерэг соёл бол спорт", "Эерэг хандлага-байгаа байгаагаа бэлэглэе" сэдвээр Дорнод аймгийн УЦУОШТ "Ёс зүйтэй хүн" сэдвээр, Ховд аймгийн УЦУОШТ "Хүндэлье-Энэрье" сэдвээр, Орхон аймгийн УЦУОШТ "Насан туршийн суралцахуйн төв"-тэй хамтран Ёс зүйн сургалт, Баянхонгор аймгийн УЦУОШТ "Эрүүл мэндийн боловсрол-харилцааны соёл" сэдвээр, "Насан туршийн боловсролын төв"-өөс "Харилцаа, гэр бүлийн ёс зүй" сэдвээр, Говь-Алтай аймгийн УЦУОШТ-өөс "Хүндэлье-Энэрье" нөлөөллийн аяны хүрээнд "Дотно яриа" сэдвээр, Баян-Өлгий аймгийн УЦУОШТ "Ёс зүйтэй цаг уурч" сэдвээр,

Сэлэнгэ аймгийн УЦУОШТ Оймандах ёс зүйн академитай хамтран “Байгууллагын соёл-ёс зүй” сэдвээр, Булган аймгийн УЦУОШТ “Ажлын байран дахь сэтгэл зүйн эрүүл мэнд”, “Ёс зүйн хандлага-Иргэн төвтэй үйлчилгээ” сэдвээр, Архангай аймгийн УЦУОШТ “Ёс зүй, харилцаа хандлага, анхаарах асуудал” сэдвээр, Сүхбаатар аймгийн УЦУОШТ “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” “Харилцааны ёс зүй,стресс менежмент”, “Иргэний ёс зүйн боловсрол”, “Гэр бүлд эцэг эхийн оролцоо”, “Зөв хандлага эерэг нөлөө”, сэдвээр, Дорноговь аймгийн УЦУОШТ “Хувь хүний хөгжил”, “Байгууллагын соёл” сэдвээр жилийн болон сарын аянуудыг тус тус зохион байгуулан ажилласан байна.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хороо 2025 онд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн 2 дүгнэлт, харьяа байгууллагын ёс зүйн дэд хороонд нэг зөвлөмж гаргаж, хуулийн дагуу томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.
   Төв, орон нутгийн харьяа 25 байгууллагаас ёс зүйн зөрчил гаргасан эсэх дүгнэлт 9 удаа гаргаж томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн 5 байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргасан, 2 байгууллагын удирдах албан тушаалтан шийдвэр гаргаагүй байна.
2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг төв, орон нутгийн харьяа 26 байгууллагын 25 нь байгууллагын албан ёсны сайтад байршуулсан байна. Цаг уур, орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хороо нь вэб сайтыг шинээр хийж байрлуулсан бөгөөд бусад салбар дэд хороодод үлгэр жишээ болохуйц байгаа талаар Монгол улсын ёс зүйн хорооны Ёс зүйн дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болорзул салбарын албан хаагчидтай уулзах үеэр онцолсон. Ёс зүйн дэд хорооноос хийж хэрэгжүүлсэн сургалт хөтөлбөр, дүгнэлттэй холбоотой мэдээллийг байршуулан ажиллаж байна.
3. Цаг уур, орчны шинжилгээний газраас Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллын асуудлыг бүрэн шийдвэрлэн олгож ирсэн. 2025 оны 12 дугаар сараас Төрийн сангийн программд Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал олгох цэс байхгүй болсонтой холбоотой олгогдоогүй байна. Харьяа 9 байгууллага ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал олгож, 17 байгууллага олгоогүй байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

1. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдлыг авч үзвэл 26 байгууллагаас 2 байгууллага /Баянхонгор, Булган/ шилжилт хөдөлгөөнийг бүртгээгүй байна.
2. Цаг уур, орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хороо 2025 онд 5 өргөдөл гомдол бичгээр хүлээн авч 2 гомдлыг эвлэрүүлж, нэг гомдлыг хариуцагч эргүүлэн татсан, 2 гомдолд ёс зүйн зөрчил гаргасан эсэх дүгнэлтийг гарган ажиллалаа. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагууд 9 гомдол нийт 11 дүгнэлт гаргаж, цахим хяналтын дэд системд бүртгэж ажилласан байна. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд дүгнэлт шийдвэрийг бүртгэн ажиллаж байна.
3. Цаг уур, орчны шинжилгээний газрын ёс зүйн дэд хороо нь Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг тухай бүрт нь бүртгэлээ.

Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл
2025 онд байгууллагын албан хаагчид болон харьяа байгууллагын албан хаагчдад өөрийн байгууллагад тулгардаг сэдвүүдээр сургалт зохион байгуулсан нь үр дүнтэй үйл ажиллагаа болж төрийн албан хаагчийн ёс зүйн	Эрдэмтэн судлаачид, илтгэгч нараас сургалт авахад төлбөрийн асуудал гарч байгаа нь сонирхсон чиглэлээр сургалт авч, соён гэгээрүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байна. Төв орон нутгийн харьяа байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын

талаарх ойлголт сайжирч, хариуцлага хандлага сайжирсан гэж дүгнэж байна.	гишүүдийн урамшуулал нь батлагдсан төсөв хүрэлцэхгүй байгаатай холбогдуулан зарим байгууллагуудад олгогдох боломжгүй байна.
Санал: Байхгүй	

Шалгах хэсэг:

☑ Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн эсэх

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:
Томилох эрх бүхий албан тушаалтан
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Э.БАТТУЛГА

Ёс зүйн дэд хорооны дарга
ЦАГ УУРЫН САЛБАРЫН
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Н.ЭНХМАА

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
МЭДЭЭЛЛИЙН СТУДИ ХАРИУЦСАН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР М.БАТЖАРГАЛ

БАТЛАВ.

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Н.ЭНХМАА

ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.17

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа		Хариуцах ёс зүйн дэд хорооны гишүүн
				Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	
1	“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт сургалт зохион байгуулах	-Сургалтын тоо -Сургалтад хамрагдсан албан хаагч, хувь	-1 -нийт албан хаагчийн 90 дээш хувийг хамруулсан байна.	1		Ёс зүйн дэд хорооны гишүүд
2	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулах /Суралцагч байгууллага-байгууллагын соёл/	-Сургалтын тоо -Сургалтад хамрагдсан албан хаагч, хувь	-3 удаагийн сургалт -нийт албан хаагчийн 90 дээш хувийг хамруулсан байна.	1	2	Ёс зүйн дэд хорооны гишүүд
3	Харьяа байгууллагуудад соён гэгээрүүлэх цахим сургалтыг зохион байгуулах	-Сургалтын тоо	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн	1	1	Ёс зүйн дэд хорооны гишүүд

		-Сургалтад хамрагдсан албан хаагч, хувь	80 дээш хувийн хамруулсан байна.			
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар видео контент хийх, түгээх	-Контентийн тоо -Хандалтын тоо	-1 контент - >70		1	НБД. М.Батжаргал
5	“Шударга ёс, хөгжил дэвшилд” мэдээллийн самбарт төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой мэдээлэл тавих	-Тавьсан мэдээллийн тоо - тогтмолжуулсан байдал	-6 мэдээлэл 2 сард тутамд шинэчилж хэвшсэн байх	3	3	НБД. М.Батжаргал
6	Ёс зүйн дэд хорооноос эерэг байдлыг уриалсан аян зохион байгуулах	-Аяны тоо -Аянд хамрагдсан албан хаагч, хувь	-1 аян -нийт албан хаагчийн 80 дээш хувь хамрагдсан байна.	1	1	Ёс зүйн дэд хорооны гишүүд
7	Шинээр ажилд орсон албан хаагч нарт ёс зүйн асуудлаар 8 цагийн сургалт өгөх, асуумж бөглүүлэх	Ёс зүйн талаарх мэдлэг сайжирсан байдал, хувь	Ёс зүйн тухай ойлголт 60 ба түүнээс дээш хувиар нэмэгдсэн байна.	Тухай бүрт	Тухай бүрт	Ёс зүйн дэд хорооны гишүүд
8	Зөрчлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, захиргаа, аудитын хэлтэс болон албан хаагчдад зөвлөмж хүргүүлэх	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	1		1	Ёс зүйн дэд хорооны гишүүд
9	Цахимаар болон цаасаар ирсэн гомдол, мэдээллийг хүлээн авах, судлах, ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг гаргах	-Хугацаа	-30 хоногийн дотор дүгнэлт гаргасан байх	Тухай бүрт	Тухай бүрт	НБД. М.Батжаргал

10	Ёс зүйн зөрчлийн байдалд үнэлгээ өгөх асуумж авах, дүгнэлт гаргах	-Дүгнэлтийн тоо	2	1	1	Ёс зүйн дэд хорооны гишүүд
11	Байгууллагын албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ хийх /Ёс зүйн хорооноос гаргасан арга хэмжээний дагуу/	-Хамрагдсан албан хаагчийн тоо, хувиар	- 80-аас дээш хувь нь хамрагдсан байна		1	Ёс зүйн дэд хорооны гишүүд
12	Ёс зүйн цахим дэд системд мэдээлэл оруулах	Хэрэгжилтийн хувь	100% Бүх мэдээлэл бүрэн орсон байна.	Тухай бүрт	Тухай бүрт	НБД. М.Батжаргал
13	Цахим сайтыг баяжуулах	Улирал бүр	Мэдээлэл шинэчлэгдэх	2	2	Ёс зүйн дэд хорооны гишүүд

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА М.БАТЖАРГАЛ